

## **ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛ, ХҮСЭЛТ ШИЙДВЭРЛЭЛТИЙН 2023 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН**

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агентлагууд нь байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг бичгээр, амаар, цахим сүлжээ, санал хүсэлтийн хайрцаг, нээлттэй 70543434 дугаарын нээлттэй утсаар хүлээн авч, холбогдох албан тушаалтанд танилцуулж, бүртгэл хяналтын картаар шийдвэрлэлтийн байдалд хяналт тавин, ажиллаж байна.

**Аймгийн Засаг даргад хандаж ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтэд тусгагдсан асуудлыг ангилан авч үзвэл:**

- Гэр хүсэх тухай-5
- Байрны түрээсийн дэмжлэг хүсэх тухай-4
- Дэмжлэг хүссэн-9
- Газрын асуудлаар-6
- Тусламж хүсэх тухай-6

Аймгийн Засаг даргад гэр хүсэх тухай 5 өргөдөл ирснийг судлан, гэр олгох боломжгүй тухай мэдэгдсэн. Тусламж хүссэн 6 иргэний өргөдлийг шийдвэрлэн 3.0 сая төгрөгийн тусламж үзүүлсэн. Мөн дэмжлэг хүссэн 7 иргэний өргөдлийг шийдвэрлэж, нийт 3.3 сая төгрөгийн дэмжлэгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс олгож, 2 иргэний өргөдөл шийдвэрлэх шатанд байна. Газрын асуудлаар ирүүлсэн 6 өргөдлийг хууль, журмын дагуу шийдвэрлэсэн. Аймгийн Засаг даргад иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэн ажиллаж байна. 2023 оны хагас жилийн байдлаар хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлт байхгүй, хугацаа болоогүй шийдвэрлэх шатанд 7 өргөдөл байна.

Сумдын Засаг дарга нарт нийт 243 өргөдөл ирсэн бөгөөд төрлөөр нь ангилбал:

- Асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоолгох тухай-6 (Судлан үзэж сумын Засаг даргын захирамжаар асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоосон)
- хүүхэд үрчлэх хүсэлт -2 (хамтарсан багаар шийдвэрлэсэн)
- Буцалтгүй тусламж хүссэн-7 (Сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс 4.4 сая төгрөгийн тусламж үзүүлсэн)
- Дэмжлэг хүссэн –5 иргэний өргөдлийг шийдвэрлэн нийт 3040500 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.
- Худаг, усны асуудлаар-1 өргөдөл ирснийг аймгийн Байгаль орчин, аялал, жуулчлалын газарт хүсэлтийг хүргүүлээд байна.
- Газрын асуудлаар-40 (өргөдлийг хууль журмын дагуу сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хэлэлцүүлэу шийдвэрлэсэн)
- Тусгай зөвшөөрөл шинээр авах 7 хүсэлтийг судлан хууль, журмын дагуу шаардлага хангасан тул тусгай зөвшөөрлийг олгосон.
- Бусад асуудлаар-4 өргөдөл ирснийг шийдвэрлэсэн.

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**